ХУУЛЬ БУСААР ОРШИН СУУГАА ИРГЭДИЙГ
БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ
АВСТРИЙН ХОЛБООНЫ ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР
(БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ХЭЛЭЛЦЭЭР)

Австрийн Холбооны Засгийн Газар нь болон Монгол Улсын Засгийн Газар (цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэх)

Хоёр улсын болон иргэдийн найрсаг харилцаанд тулгуурлаж;

Хууль бус шилжилт хөдөлгөөнтэй үр дүнтэй тэмцэх хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэж;

Энэхүү хэлэлцээрт үндэслэн Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, эсхүл оршин суухтай холбоотой шаардлагыг хангахгүй, эсхүл хангахаа больсон иргэдийг олж тогтоох, буцаан шилжүүлэх ажиллагааг харилцан үр дүнтэй, түргэн шуухай гүйцэтгэх процедурыг бий болгохыг зорьж;

Нэг бүрчлэн, эмх цэгцтэй шалгах зарчмын дагуу иргэдийг буцаан шилжүүлэхийг санаж;

Нэг талаас Европын холбоо болон түүний гишүүн улсууд, нөгөө талаас Монгол Улс хамтран байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”-ийн 31 болон 58 дугаар зүйл, мөн 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн “Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц”, 2000 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” болон түүний нэмэлт протоколууд, тухайлбал, “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, “Газар, далай, агаарын замаар цагаачдыг хууль бусаар нууцаар тээвэрлэхийг таслан зогсоох тухай протокол”-ыг баримтлан;

Дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл
Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

1. “Иргэн” Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэгнийх нь харьяаллыг хадгалж буй аливаа хувь хүнийг хэлнэ.

2. “Хууль бусаар оршин суугч” гэж үндэсний хууль тогтоомжийн дагуу бий болсон холбогдох процедураар Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэгнийх нь нутаг дэвсгэрт нэвтрэх, эсхүл оршин суух хүчин төгөлдөр болзлыг хангахгүй, эсхүл хангахаа больсон аливаа иргэнийг хэлнэ.

3. “Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал” гэж энэхүү хэлэлцээрийн хүрээнд иргэнийг буцаан шилжүүлэх хүсэлт, эсхүл шилжүүлэх мэдэгдэл гаргагч Хэлэлцэн тохирогч талыг хэлнэ.

4. “Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал” гэж энэхүү хэлэлцээрийн хүрээнд иргэнийг буцаан шилжүүлэх хүсэлт, эсхүл шилжүүлэх мэдэгдлийг хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талыг хэлнэ.

5. “Буцаан шилжүүлэх” энэхүү хэлэлцээрийн дагуу Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт нэвтрэх, эсхүл оршин суух болзлыг хангаагүй буюу хангахаа больсон иргэнийг Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал шилжүүлэн өгөх болон Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал шилжүүлэн авах үйл ажиллагааг хэлнэ.

6. “Оршин суух зөвшөөрөл” гэж Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагаас олгосон тухайн талын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суухыг зөвшөөрсөн хүчин төгөлдөр зөвшөөрлийг хэлнэ. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу оршин суух виз, оршин суух зөвшөөрөл, эсхүл орогнол хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэсний үндсэн дээр олгох тухайн нутаг дэвсгэрт түр оршин суух зөвшөөрөл нь энэ тодорхойлолтод хамаарахгүй.

7. “Виз” гэж Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэгнийх нь нутаг дэвсгэрт нэвтрэх, богино хугацаагаар оршин суух, дамжин өнгөрөхөд шаардагдах зөвшөөрөл буюу шийдвэрийг хэлнэ. Энэ нэр томъёонд нисэх онгоцны буудлын дамжин өнгөрөх виз хамаарахгүй.

2 дугаар зүйл
Өөрийн иргэнийг буцаан шилжүүлэн авах

1. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэр дээр хууль бусаар оршин сууж буй иргэд нь Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын харьяат болох нь нотлогдсон тохиолдолд эдгээр иргэдийг Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал нь энэхүү Хэлэлцээрт заасан албан ёсны нөхцөлүүдээс бусад нэмэлт нөхцөл шаардахгүйгээр Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талаас

гаргасан хүсэлтийн дагуу буцаан шилжүүлэн авна. Тухайн иргэдийн иргэншлийг нотлох баримтыг 2 дугаар хавсралтад дурдсан аль ч баримт бичгээр нэмэлт нөхцөл шаардахгүйгээр баталгаажуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө тал өөрөөр нотлоогүй бол иргэний харьяаллыг нотлох баримтыг 3 дугаар хавсралтад заасан баримт бичгүүдийн аль нэгээр нь нэмэлт нөхцөл шаардахгүйгээр гаргаж болно.

3. Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал нь дараах иргэдийг мөн буцаан шилжүүлэн авна. Үүнд:

   - Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт дурдсан иргэдийн 18 (арван найман) нас хүртэлх насанд хүрээгүй, гэрлээгүй хүүхдүүд нь Хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт бие даан оршин суух эрхгүй бол эдгээр хүүхдүүдийг тэдний төрсөн газар болон иргэншлээс үл хамааран буцаан шилжүүлэн авна;

   - Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт дурдсан иргэдийн өөр улсын иргэншилтэй эхнэр/нөхөр нь Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суух эрхтэй, эсхүл уг эрхийг авах боломжтой ба Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт бие даан оршин суух эрхгүй тохиолдолд Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал нь эдгээр иргэдийг буцаан шилжүүлэн авна.

4. Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал нь Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт нэвтрэх буюу хууль ёсоор оршин суух хүчин төгөлдөр болзлыг хангаагүй, эсхүл цаашид хангахаа больсон бөгөөд иргэншлийг нь Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал хүчингүй болгосон, мөн Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт нэвтэрснээс хойш Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн улсын иргэншлээсээ татгалзсан иргэдийг буцаан шилжүүлэн авна. Гэхдээ эдгээр иргэдэд Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талаас иргэншил олгохоор амлалт өгсөн тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй.

5. Хэрэв хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн бол, Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал нь буцаан шилжүүлэн авах иргэний хүсэл зоригоос үл хамааран, боломжит хамгийн богино хугацаанд буюу зөвшөөрөл олгосноос хойш ажлын 10 (арав) хоногийн дотор буцаан авахад шаардлагатай, хамгийн багадаа 6 (зургаан) сарын хугацаанд хүчинтэй байх зорчих баримт бичгийг олгоно. Хэрэв Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал нь хууль зүйн, эсхүл бодит шалтгааны улмаас тухайн иргэнийг уг зорчих баримт бичгийн хүчинтэй хугацаанд

шилжүүлээгүй бол, Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал нь өмнөхтэй адил хүчинтэй хугацаатай шинэ зорчих баримт бичгийг аль болох хурдан буюу өмнөх баримт бичгийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш ажлын 10 (арав) хоногийн дотор олгоно.

6. 2, 3 дугаар хавсралтад заасан баримт бичгүүдийн аль нь ч байхгүй тохиолдолд буцаан шилжүүлэн авах хүсэлтэд тухайн иргэний харьяаллыг тогтоолгохоор Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын дипломат болон консулын төлөөлөгчийн газарт ярилцлага хийх хүсэлтийг тусгана. Ярилцлагыг буцаан шилжүүлэх хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 (арав) хоногийн дотор явуулах бөгөөд харилцан зөвшилцсөний үндсэн дээр аудио, видео систем ашиглан хийж болно. Хэрэв тухайн иргэний иргэншлийг тогтоож баталгаажуулсан тохиолдолд, зорчих баримт бичиг/яаралтай зорчих баримт бичгийг дараагийн ажлын 10 (арав) хоногийн дотор олгоно. Энэ зүйлд энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан буцаан шилжүүлэн авах хүсэлтэд хариу өгөх хугацааг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл
Буцаан шилжүүлэх хүсэлт

1. Энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн үндсэн дээр буцаан шилжүүлэн авах иргэнийг шилжүүлэхдээ Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагад бичгээр буцаан шилжүүлэн авах хүсэлтээ гаргана.

2. Буцаан шилжүүлэн авах хүсэлтэд дараах зүйлийг тусгана. Үүнд:
   - Буцаан шилжүүлэх иргэний тухай мэдээлэл (нэр, овог, төрсөн огноо, боломжтой бол ургийн овог, төрсөн газар, сүүлд оршин сууж байсан газар);
   - Иргэншлийг баталгаажуулсан буюу анхан шатны нотолгоо болох баримт бичгийн хуулбарууд (2 ба 3 дугаар хавсралт);
   - Буцаан шилжүүлэн авах иргэний зураг;
   - Буцаан шилжүүлэн авах иргэний хурууны хээ.

3. Хэрэв шаардлагатай бол буцаан шилжүүлэн авах хүсэлтэд дараах мэдээллийг багтаасан байна:
   - Буцаан шилжүүлэх иргэний өөрийнх нь зөвшөөрлөөр эрүүл мэндийн тусламж, асрамж, эсхүл дэмжлэг хэрэгтэй эсэх талаар болон тухайн иргэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бусад мэдээлэл;
   - Шилжүүлгийн явцад тухайн иргэнд ямарваа нэгэн хамгаалалт болон аюулгүй байдлын арга хэмжээ авах шаардлагатай эсэх талаар бусад мэдээлэл.

4. Буцаан шилжүүлэн авах хүсэлтийг харилцаа холбооны ямар ч хэлбэрээр гаргаж болох бөгөөд нийтлэг ашиглагдах цахим холбооны хэрэгсэл буюу цахим шуудан эсхүл онцгой тохиолдолд ашиглагдах факсын маягтуудыг 4 дүгээр хавсралтаар оруулсан болно.

5. Хэрэв буцаан шилжүүлэн авах иргэн нь хүчинтэй зорчих бичиг баримттай тохиолдолд буцаан шилжүүлэн авах хүсэлт гаргах шаардлагагүй.

4 дүгээр зүйл
Буцаан шилжүүлэх ажиллагаа

1. Цахим хэлбэрээр илгээсэн буцаан шилжүүлэн авах хүсэлтийн хариуг бичгээр, аль болох түргэн шуурхай буюу ажлын 30 (гучин) хоногийн дотор мэдэгдэнэ. Хариу өгөх хугацаа нь Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагаас буцаан шилжүүлэн авах хүсэлтийг хүлээн авсан (цахим харилцаа холбооны хэрэгслийн баталгаажуулалтаар мэдэгдсэн) өдрөөс эхлэн тоологдох бөгөөд хэрэв хууль зүйн, эсхүл бодит шалтгааны улмаас буцаан шилжүүлэн авах хүсэлтэд хугацаанд нь хариу өгч чадахааргүй болсон тохиолдолд Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр энэхүү хугацааг ажлын 60 (жаран) өдрөөс илүүгүй хугацаагаар сунгаж болно. Хэрэв энэ хугацааны дотор буцаан шилжүүлэн авах хүсэлтэд хариу өгөөгүй бол тухайн хүсэлтийг зөвшөөрсөн гэж үзнэ. Хэрэв буцаан шилжүүлэн авах хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлээ бичгээр хариу мэдэгдэнэ.

2. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага нь буцаан шилжүүлэх хүсэлтийг зөвшөөрсний үндсэн дээр, мөн зорчих баримт бичгийг олгосны дараа, шилжүүлэг хийх огноо, хилээр гарах цэг, боломжит дагалдан явагч нар болон шилжүүлэгтэй холбоотой бусад мэдээллийг Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагад бичгээр, урьдчилан мэдэгдэнэ.

3. Иргэнийг шилжүүлэх ажиллагааг аль болох түргэн шуурхай буюу зөвшөөрлийг хүлээн авснаас хойш ажлын 180 (нэг зуун наян) хоногийн дотор явуулна. Энэхүү хугацааг Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр хууль зүйн болон бодит шалтгааны улмаас үүссэн саад бэрхшээлийг даван туулахад шаардагдах хугацаагаар сунгаж болно.

5 дугаар зүйл
Буцаан шилжүүлэх арга хэмжээ, тээвэрлэлтийн хэлбэр

1. Буцаан шилжүүлэх ажиллагаа үндсэндээ агаарын тээврээр хийгдэх боловч газраар тээвэрлэх байдлаар мөн хийгдэж болно. Агаарын тээврээр буцаан шилжүүлэх ажиллагаанд Хэлэлцэн тохирогч Талуудын үндэсний агаарын тээвэрлэгчийг, эсхүл Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын хамгаалалтын ажилтныг ашиглахыг хориглоогүй бөгөөд хуваарьт, эсхүл тусгай үүргийн нислэгээр дамжуулан хэрэгжүүлж болно. Мөн шууд болон транзит нислэгийн хэлбэрүүдийг ашиглахыг зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэгний дагалдан явагч нар нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт зорчих үедээ бүрэн эрхт байдлын аливаа үйлдэл хийх ёсгүй.

6 дугаар зүйл
Алдаатай буцаан шилжүүлэлт

1. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал аливаа иргэнийг буцаан шилжүүлсэнээс хойш ажлын гуч (30) хоногийн дотор тухайн иргэн нь энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангаагүй талаар Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал тогтоосон бол Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал нь тухайн иргэнийг үндэслэл бүхий хүсэлтийн дагуу буцаан авна. Хүсэлтэд буцаан авах хүний бодит нэр, иргэншлийн талаарх боломжит бүх мэдээллийг багтаана.

2. Дээрх тохиолдолд, энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан процедурыг төсөөтэй хэрэглэж (*mutatis mutandis*), буцаан авах хүний бодит нэр, иргэншлийн талаарх боломжит бүх мэдээллийг гаргаж өгнө.

7 дугаар зүйл
Зардал

Энэхүү Хэлэлцээрийн дагуу буцаан шилжүүлэхтэй холбоотойгоор Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрийн хил хүртэл гарсан бүх тээврийн зардлыг Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал хариуцна. Үүнд мөн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу буцаан шилжүүлэхтэй холбоотой гарсан зардалд хамаарна.

8 дугаар зүйл
Мэдээллийн хамгаалалт

1. Буцаан шилжүүлэхтэй холбоотойгоор тухай иргэнийг нэг Хэлэлцэн тохирогч талд шилжүүлэхэд шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагуудын

шийдвэрээр Хэлэлцэн тохирогч Талууд тухайн иргэний хувийн мэдээллийг харилцан солилцож болно. Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд хувийн мэдээллийг харилцан дамжуулах болон энэ төрлийн мэдээллийг цаашид боловсруулах үйл явц нь холбогдох үндэсний хууль тогтоомжууд болон мэдээллийг дамжуулж буй Хэлэлцэн тохирогч талаас тавьсан нөхцөлүүдийг баримтлан явагдах бөгөөд дараах автоматжуулсан болон автоматжуулалтад ороогүй мэдээллийн боловсруулалтад ижил байдлаар үйлчлэх зарчмуудын дагуу зохицуулагдана. Үүнд:

a. Хувийн мэдээллийг хууль ёсны дагуу, үнэнч шударгаар, холбогдох иргэнд ил тод байдлаар боловсруулна. Тэдгээрийг зөвхөн энэхүү Хэлэлцээрт заасан, тодорхой, хууль ёсны зорилгоор боловсруулна. Мэдээллийг хүссэн зорилго, шилжүүлэх мэдээллийн мөн чанар хооронд шалтгаант холбоо байх ёстой бөгөөд энэ нь мэдээллийг боловсруулах зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмжээнд хязгаарлагдах ёстой. Ямар ч тохиолдолд зөвхөн дараах хүний хувийн мэдээллийг дамжуулж болно:
   - Тухайн хүний хувийн мэдээлэл (нэр, овог, шаардлагатай бол өмнө ашиглаж байсан нэр, хоч, төрсөн огноо болон газар, хүйс, одоогийн болон өмнөх иргэншил);
   - Иргэний үнэмлэх, паспорт, жолооны үнэмлэх (дугаар, хүчинтэй хугацаа, олгосон огноо, олгосон байгууллага, олгосон газар), эсхүл 2-4 дүгээр хавсралтад заасан бусад баримт бичиг;
   - Хэрэв энэхүү Хэлэлцээрийн дагуу буцаан шилжүүлэх нөхцөлийг хангахад шаардлагатай бол байршил болон аяллын маршрутын талаарх мэдээлэл;
   - Хэрэв тухайн хүний иргэншил болон бусад мэдээллийг дээрх баримт бичгүүдийн аль нэгээр тодорхойлох боломжгүй бол, буцаан шилжүүлэх нөхцөлийг хангахад шаардагдах бусад мэдээлэл.
b. Мэдээлэл дамжуулагч Хэлэлцэн тохирогч тал өөр зорилгоор өгөгдлийг боловсруулахыг тусгайлан зөвшөөрөөгүй бол дамжуулсан хүний хувийн мэдээллийг зөвхөн дамжуулсан зорилгын хүрээнд боловсруулна.

c. Хувийн мэдээлэл үнэн зөв байх бөгөөд шаардлагатай бол түүнийг цаг тухайд нь шинэчилнэ; хувийн мэдээллийг засварлах, устгах, хаахын тулд бүх боломжит арга хэмжээг авна. Хувийн мэдээллийг зөвхөн түүнийг боловсруулах зорилгод нийцүүлэн тухайн иргэнийг тодорхойлох боломжтой байдлаар хадгална.

2. Хувийн мэдээллийг боловсруулж, хадгалахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах ёстой бөгөөд энэ нь зөвшөөрөгдөөгүй, эсхүл хууль бус боловсруулалт, санамсаргүй алдах, санамсаргүй устгах, эсхүл гэмтээхээс хамгаалах арга

хэмжээ авах замаар хангагдах болно. Үүний тулд зохих техник болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Талууд мэдээлэл дамжуулах, хүлээн авах бүрийг баримтжуулах үүрэгтэй. Энэхүү баримт бичигт дамжуулах, хүлээн авах зорилго, агуулга, огноо, түүнчлэн дамжуулах, хүлээн авах эрх бүхий байгууллагын мэдээллийг багтаана. Энэ нь тухайн дамжуулсан мэдээллийг устгахад мөн адил хамаарна. Баримт бичгийг зохисгүй ашиглах болон буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах замаар хамгаалах бөгөөд гурван (3) жилийн турш хадгалагдана. Энэ хугацаа дуусмагц баримт бичгийг нэн даруй устгалд оруулна. Баримт бичгийг зөвхөн Хэлэлцэн тохирогч Талуудын холбогдох мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг баримталсан эсэхийг шалгахад ашиглана.

4. Холбогдох иргэн нь нь эрх бүхий байгууллагад өөрийгөө баталгаажуулан хүсэлт гаргаснаар энэхүү Хэлэлцээрийн дагуу дамжуулсан, эсхүл боловсруулсан тухайн иргэний хувийн мэдээлэл, түүний эх үүсвэр, хүлээн авагчид мэдээлэл дамжуулсан зорилго, хууль зүйн үндэслэл зэрэг мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр, түргэн шуурхай, үнэ төлбөргүйгээр авах эрхтэй. Мөн иргэн бүр буруу мэдээллийг засах болон хууль бусаар боловсруулсан мэдээллийг устгахыг шаардах эрхтэй.

   Хэрэв холбогдох иргэн өөрийнх нь мэдээллийн аюулгүй байдлын эрх зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд нь холбогдох иргэнийг “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц”-ын (Хүний эрхийн тухай Европын конвенц) 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хуулийн дагуу байгуулагдсан, хараат бус, шударга шүүхээр үр дүнтэй шүүлгэх эрхээр, мөн Европын Зөвлөлийн 1981 оны 1-р сарын 28-ны өдрийн "Хувь хүний мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой конвенц”-ын 2001 оны 11-р сарын 8-ны өдрийн “Нэмэлт протоколын” 1 дүгээр зүйлд заасны дагуу бие даасан хяналтын байгууллагад гомдол гаргах эрхээр, түүнчлэн өөрийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шаардлагатай бол нөхөн олговор шаардах зэрэг эрхүүдээр хангана. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх журмыг тухайн иргэний мэдээллийн аюулгүй байдлын эрхийг зөрчсөн Хэлэлцэн тохирогч талын үндэсний хууль тогтоомжоор зохицуулна. Дээрх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийг эзэмшиж буй Хэлэлцэн тохирогч тал хүсэлтийг шийдвэрлэхээс өмнө мэдээллийг дамжуулагч Хэлэлцэн тохирогч талыг хариу тайлбар өгөх боломжоор хангана.

5. Энэхүү Хэлэлцээрийн дагуу дамжуулагдсан хүний хувийн мэдээллийг цааш нь өөр гуравдагч этгээдэд дамжуулахыг зөвхөн мэдээлэл дамжуулагч Хэлэлцэн тохирогч талын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ. Уг зөвшөөрлийг зөвхөн мэдээлэл дамжуулагч Хэлэлцэн тохирогч талын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд олгоно. Дамжуулан авсан хүний хувийн мэдээлэл нь нууц байна.

6. Дамжуулагдсан хүний хувийн мэдээллийг дамжуулах болсон зорилго нь биелэгдсэн, эсхүл тус зорилго нь үгүй болсон тохиолдолд даруй устгана. Дамжуулагч Хэлэлцэн тохирогч тал нь нөгөө Хэлэлцэн тохирогч талаас хувийн мэдээллийг устгасан тухай мэдэгдлийг хүлээн авна.

7. Мэдээлэл хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал мэдээлэл дамжуулагч Хэлэлцэн тохирогч талд тус талын гаргасан хүсэлтийн дагуу дамжуулсан мэдээллийг боловсруулалтын талаар болон олж авсан үр дүнгийн талаар мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл
Хэл

Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд “Буцаан шилжүүлэх” Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа нь англи хэлээр явагдана.

10 дугаар зүйл
Хавсралтууд

1. Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад тусгасан болно.

2. 1-4 Хавсралтууд нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг болно.

11 дүгээр зүйл
Олон улсын бусад гэрээтэй харилцан хамаарал

Энэхүү Хэлэлцээр нь олон улсын бусад гэрээ, хэлэлцээр, үндэстэн дамнасан болон олон улсын байгууллагын гишүүнчлэлээс бий болох эрх, үүргийг хөндөхгүй.

12 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад гарч болох бүх маргааныг харилцан зөвшилцөн шууд зөвлөлдөх замаар шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

Хэлэлцэн тохирогч тал бүр шаардлагатай бол нөгөө Хэлэлцэн тохирогч талыг энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар хэлэлцүүлэгт урьж болно.

13 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох, үйлчлэх хугацаа болон дуусгавар болох

1. Энэхүү Хэлэлцээр нь сүүлийн Хэлэлцэн тохирогч тал нь түүнийг хүчин төгөлдөр болгох үндэсний хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа нөгөө Хэлэлцэн тохирогч талдаа мэдэгдсэн өдрөөс хойш хоёр дахь сарын эхний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрийг хугацаагүй байгуулав.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нь ч нөгөө талдаа дипломат шугамаар бичгэн мэдэгдэл хүргүүлэх замаар нийтийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийн шалтгаанаар энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг бүрэн, эсхүл хэсэгчлэн түр хугацаанд зогсоож болно. Ийнхүү зогсоох явдал нь дээрх мэдэгдэл өгсөн өдрөөс хойш хоёр дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү Хэлэлцээрт Хэлэлцэн тохирогч Талууд харилцан зөвшөөрсөнөөр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлтийг энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болох тусдаа протокол хэлбэрээр үйлдэх бөгөөд энэхүү зүйлийн (1) дэх хэсэгт заасан процедурын дагуу хүчин төгөлдөр болно.

5. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь нөгөө талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдсэнээр энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно. Цуцлах тухай мэдэгдлийг нөгөө Хэлэлцэн тохирогч тал нь хүлээн авсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын дараа энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг ..... хотноо ..... оны ..... сарын ..... -ны өдөр монгол, герман, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

АВСТРИЙН ХОЛБООНЫ ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ	**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Хавсралт 1: Хэрэгжилттэй холбоотой заалтууд

1 дүгээр зүйл

Эрх бүхий байгууллагыг томилох

1. Австрийн талаас энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага нь:

    a. Буцаан шилжүүлэх хүсэлтийг илгээхэд:

    Холбооны Дотоод хэргийн яамны Цагаачлал болон орогнолын асуудал хариуцсан Холбооны газар

    b. Буцаан шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн зөвшөөрөхөд:

    Холбооны Дотоодын хэргийн яам:

2. Монголын талаас энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага нь:

    a. Буцаан шилжүүлэх хүсэлтийг илгээх

    Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газар

3. Энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн дагуу буцаан шилжүүлэх тухай хүсэлтийг цахимаар, эсхүл онцгой тохиолдолуудад факсаар илгээнэ. Илгээсэн хүсэлтийн нотолгоог хүсэлтийг хүлээн авсан нотлох баримт гэж үзээд энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан хугацааг тооцож эхэлнэ.

4. Энэхүү зүйлд дурдсан эрх бүхий байгууллага, газар нэгжтэй холбоотой аливаа өөрчлөлт, холбоо барих мэдээллийг нэн даруй дипломат шугамаар харилцан солилцоно.

2 дугаар зүйл

Хилийн нэвтрэх цэг

1. Шилжүүлэх ажиллагааг агаараар гүйцэтгэх тохиолдолд Австри Улсын нутаг дэвсгэр дэх хилийн нэвтрэх цэг:

    Вена Олон улсын нисэх онгоцны буудал
    Вена-Швехат

Хотын цагдаагийн хэлтэс Швехат
Хилийн цагдаагийн газар

2. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хилийн нэвтрэх цэг:

   Буянт-Ухаа олон улсын нисэх онгоцны буудал
   Улаанбаатар, Монгол

3. Хэлэлцэн тохирогч талууд урьдчилан зөвлөлдсөний үндсэн дээр буцаан шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэхдээ зарим тохиолдолд 1 дэх хэсэгт дурдсан хилийн нэвтрэх цэгээс бусад байршлыг ашиглаж болно.

4. Хэлэлцэн тохирогч талууд 1 дүгээр зүйлд дурдсан эрх бүхийн байгууллага, 1 болон 2 дахь хэсэгт дурдсан Хилийн нэвтрэх цэгтэй холбоо барих мэдээлэл болон эдгээр мэдээлэлд орсон нэмэлт өөрчлөлтийг дипломат шугамаар харилцан солилцоно.

3 дугаар зүйл
Шилжүүлэх ажиллагаа болон тээвэрлэлтийн хэлбэр

1. Хүсэлт хүлээн авагч хэлэлцэн тохирогч Талаас буцаан шилжүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрсний дараа, эсхүл хариу өгөлгүйгээр энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд Хүсэлт гаргагч тал энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талд дараах мэдээллийг агуулсан мэдэгдэлийг бичгээр хүргүүлнэ:

   - Тээвэрлэлтийн хэлбэр (агаараар, эсхүл газраар);
   - Шилжүүлэх огноо;
   - Шилжүүлэх цаг;
   - Нэвтрэх цэг (Хилийн шалган нэвтрэх цэг) болон;
   - Буцаан шилжүүлэх ажиллагааг дагалдан явах эсэх, харгалзан дагах бол шаардлагатай тохиолдолд очих газарт нь хамгаалалтын арга хэмжээ авах эсэх;

2. Мэдэгдэлийг Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагад Хавсралт 2-т дурдсан шилжүүлэх загварын дагуу 72 (далан хоёр) цагаас хэтрэхгүйгээр урьдчилж цахим шуудангаар, онцгой тохиолдолд факсаар хүргүүлнэ.

3. Хууль эрх зүйн болон бодит хүндрэлээс үүдэн Хүсэлт гаргагч хэлэлцэн тохирогч тал шилжүүлэх ажиллагааг хойшлуулах тохиолдолд, Хүсэлт гаргагч тал энэ тухай Хүсэлт хүлээн авагч хэлэлцэн тохирогч талд нэн даруй

мэдэгдэнэ. Хүсэлт гаргагч хэлэлцэн тохирогч Тал буцаан шилжүүлэх шинэчилсэн огноог нэн даруй тогтоож, энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлэх мэдэгдлийг шинээр илгээнэ.

4. Энэ зүйлийн заалтууд энэхүү Хэлэлцээрийн 3 болон 5 дугаар зүйлд адил төсөөтэй (mutatis mutandis) үйлчилнэ.

4 дүгээр зүйл
Дагалдан явагчидтай хэрэгжүүлэх буцаан шилжүүлэх арга хэмжээ

1. Хэрэв буцаан шилжүүлэх ажиллагаа нь Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын ажилтнуудаар (цаашид "Харгалзагч" гэх) дагалдуулан хийгдэх бол, Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага Харгалзагч нарын тухай дараах тухай мэдээллийг өгнө: овог, нэр; хэрэв шаардлагатай бол Харгалзагч нарын зэрэг дэв; паспортын төрөл, дугаар, олгосон огноо, хүчинтэй хугацаа; нислэгийн дугаар; ирэх, явах огноо болон цаг.

2. Харгалзагч нар нь буцаан шилжүүлэх ажиллагааны явцад өөрсдийн үнэмлэх болон эрх мэдэл, мөн буцаан шилжүүлэх ажиллагаатай холбоотой албан үүргийнхээ талаар хэдийд ч нотлох чадвартай байна. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын Харгалзагч нарын эрх мэдэл нь зөвхөн өөрийгөө болон бусдыг хамгаалах хүрээгээр хязгаарлагдана. Буцаан шилжүүлэх ажиллагааг зэвсэггүй, энгийн хувцастайгаар явуулна. Аль ч Хэлэлцэн тохирогч талын Харгалзагч нар нөгөө Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт бүрэн эрхт байдлын аливаа үйлдэл хийх ёсгүй.

3. Харгалзагч нар нь Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын дотоодын хууль тогтоомжийг чандлан мөрдөнө.

4. Харилцан зөвшилцлийн үндсэн дээр, Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт хийгдэх буцаан шилжүүлэх ажиллагааг Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагууд дэмжин ажиллах бөгөөд үүнд энэхүү ажиллагаанд оролцох иргэдийг хянах, шаардлагатай хэрэгслээр хангах зэрэг багтана.

5 дугаар зүйл
Ярилцлага явуулах журам

1. Иргэншил тогтоох ярилцлага нь зарчмын хувьд аль болох түргэн шуурхай байдлаар Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагын

байранд зохион байгуулагдах ёстой бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд зөвшилцсөний үндсэн дээр өөр тохиромжтой газар, эсхүл аудио, видео техник хэрэгсэл ашиглан явуулж болно.

2. Хэрэв буцаан шилжүүлэх ажиллагааны хүсэлтийг холбогдох иргэний иргэншлийг хангалттай тодорхойлоогүй гэх шалтгаанаар буцаасан тохиолдолд, нэмэлт ярилцлага хийх замаар иргэний харьяаллыг тогтоох шалтгаан байгаа гэж үзвэл, Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын аль нэгийн саналын үндсэн дээр уг нэмэлт ярилцлагыг аль болох түргэн шуурхай явуулна.

6 дугаар зүйл
Зардал

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь энэхүү Буцаан шилжүүлэх хэлэлцээрийн 6 дугаар зүйлд зааснаас бусад зардлыг гаргасан бол, тухайн төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн Хэлэлцэн тохирогч тал нь нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 (гуч) хоногийн дотор банкны шилжүүлгээр буцааж төлнө.

2. Хэрэв энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасны дагуу алдаатай буцаан шилжүүлэх ажиллагааг явуулсан бол, Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч тал нь буцаан шилжүүлэх иргэнийг буцаах үйл ажиллагааны зардлыг хариуцна.

ХАВСРАЛТ 2: Энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу иргэний харьяаллыг нотлох баримт бичгийн нийтлэг жагсаалт:

- Бүх төрлийн паспортууд (үндэсний паспорт, дипломат паспорт, албан паспорт болон түр, яаралтай паспортууд орно, үүнд хүүхдийн паспортууд бас хамаарна);
- Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талын олгосон Laissez-Passer баримт;
- Иргэний үнэмлэх (түр болон түр зуурын иргэний үнэмлэх орно);
- Цэргийн үнэмлэх;
- Далайчны ном болон усан онгоцны ахмадын үйлчилгээний карт;
- Иргэний харьяаллыг тодорхойлох иргэний үнэмлэх болон бусад төрлийн албан ёсны баримт бичиг.

Баримт бичгийн хүчинтэй байдал 6 (зургаан) сараас илүү хугацаанд хүчинтэй бол эдгээр баримт бичгийг иргэний харьяаллыг тогтоох нотолгоо гэж үзнэ.

ХАВСРАЛТ 3: Энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу иргэний харьяаллыг нотлох баримт бичгийн (Prima facie evidence) нийтлэг жагсаалт:

- 2 дугаар хавсралтад дурдсан хүчинтэй байдал нь зургаан (6) сараас илүүгүй хугацаагаар дууссан баримт бичгүүд;
- Визийн мэдээллийн системээс хийсэн хайгуулын үр дүнд гарсан иргэншлийн баталгаа[1];
- Энэ гэрээний 2 дугаар хавсралтад дурдсан баримт бичгүүдийн хуулбар;
- Цэргийн бүртгэлийн карт;
- Жолооны үнэмлэх;
- Төрсний гэрчилгээ;
- Холбогдох иргэний харьяаллыг тогтооход туслах бусад бүх төрлийн баримт бичиг, гэрчилгээ;
- Дээрх баримт бичгүүдийн хуулбарууд;
- Холбогдох иргэний мэдэгдлүүд;
- Холбогдох иргэний ярианы хэл;
- Гэрчүүдийн итгэмжит мэдэгдлүүд;
- Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагууд холбогдох иргэнтэй хийсэн ярилцлагын үр дүн;

[1] Визийн мэдээллийн систем (VIS) болон гишүүн орнуудын хооронд богино хугацаатай визийн талаар өгсөн мэдээллийг солилцох тухай 767/2008 тоот журам (VIS-журам), OJ L 218, 13.08.2008, хуудас 60, 2226/2017 тоот журмаар оруулсан сүүлийн нэмэлт өөрчлөлт, OJ L 327, 09.12.2017, хуудас 20.

ХАВСРАЛТ 4: Энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасны дагуу буцаан шилжүүлэх хүсэлт гаргах маягт

.....
……
.....
……
.....
……
.....
....

(Хүсэлт гаргагч улсын эрх бүхий байгууллагын нэр)

.....
.....

(Газар, огноо)

Утга: .....……

Хаана:

.....
……
.....
……
.....
……
.....
……
.....
....

(Хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын нэр)

- **ЯРИЛЦЛАГЫН ХҮСЭЛТ (2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг)**

БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ

“Хууль бусаар оршин суугаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай”
Австрийн Холбооны Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар
хоорондын Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасны дагуу
(Буцаан шилжүүлэх Хэлэлцээр)

А. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

Зураг

1. Бүтэн овог, нэр (овгийн доогуур зурж тэмдэглэх):
.....……
……
2. Төрөх үеийн нэр:
.....……
……
3. Төрсөн газар болон огноо:
.....……
……

4. Хүйс ба гадаад төрх (өндөр, нүдний өнгө, ялгах тэмдэг гэх мэт):
…….....
..……

5. Өмнө нь өөр нэртэй байсан эсэх (өмнөх нэр, ашиглаж байсан/олонд танигдсан бусад нэр):
.....…….....
.....……

6. Үндэс угсаа ба хэл:
.....…….....
.....……

7. Гэр бүлийн байдал: ☐ гэрлэсэн ☐ ганц бие ☐ салсан ☐ бэлэвсэн
Хэрэв гэрлэсэн бол эхнэр/нөхрийн нэр:
.....

Хүүхдүүдийн нэр, нас (хэрэв байгаа бол):
.....
.....

……...…….....
.....

8. Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрт сүүлд оршин сууж байсан хаяг:
.....……....
.....……....

B. ЭХНЭР/НӨХРИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ (ШААРДЛАГАТАЙ БОЛ)

1. Бүтэн овог нэр (овгийн доогуур зурж тэмдэглэх):
…….....
.....

2. Төрөх үеийн нэр:

……
…….....

3. Төрсөн газар болон огноо:
……...
.....

4. Хүйс ба гадаад төрх (өндөр, нүдний өнгө, ялгах тэмдэг гэх мэт):
…….....
..…….....

5. Өмнө нь өөр нэртэй байсан эсэх (өмнөх нэр, бусад өөр нэр/мэдэгдэж буй нэр, хоч):
.....……....
.....……....

6. Үндэс угсаа ба хэл:
.....……....
.....……..

C. ХҮҮХДҮҮДИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ (ШААРДЛАГАТАЙ БОЛ)

1. Бүтэн нэр (овгийн доогуур зурж тэмдэглэх):
…….....
.....

2. Төрсөн газар болон огноо:
……...
.....

3. Хүйс ба гадаад төрх (өндөр, нүдний өнгө, ялгах тэмдэг гэх мэт):
…….....
..…….

4. Үндэс угсаа ба хэл:

.....
.....

D. БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ИРГЭНТЭЙ ХОЛБОГДОХ ОНЦГОЙ МЭДЭЭЛЭЛ

1. Эрүүл мэндийн байдал

(жишээ нь: эмнэлгийн тусгай тусламж авах хэрэгцээ; халдварт өвчтэй бол түүний латин нэр):

.....
……

2. Онцгой аюултай хүний шинж тэмдэг бий эсэх

(жишээ нь: ноцтой гэмт хэрэгт сэжиглэгдсэн эсэх; түрэмгий зан авир бий):

.....
……

E. ХАВСАРГАХ НОТЛОХ БАРИМТУУД

1.

.....	.....
(Паспортын дугаар)	(Олгосон газар, огноо)
.....	.....
(Олгосон байгууллага)	(Дуусах хугацаа)

2.

.....	.....
(Иргэний үнэмлэхний дугаар)	(Олгосон газар, огноо)
.....	.....
(Олгосон байгууллага)	(Дуусах хугацаа)

3.

.....	.....
(Жолооны үнэмлэхний дугаар)	(Олгосон газар, огноо)
.....	.....
(Олгосон байгууллага)	(Дуусах хугацаа)

4.

.....	.....
(Бусад албан ёсны баримт бичгийн дугаар)	(Олгосон газар, огноо)
.....	.....
(Олгосон байгууллага)	(Дуусах хугацаа)

F. 2-Р ЗҮЙЛИЙН 6 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСНЫ ДАГУУ ЯРИЛЦЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ

- Буцаан шилжүүлэх Хэлэлцээрийн 2, 3 дугаар хавсралтад заасан баримт бичгүүдийн алиныг нь ч хавсаргах боломжгүй гэх шалтгааны улмаас иргэншил тогтоох ярилцлагад орох хүсэлт гаргах.

- Хавсаргасан баримт бичгийн үнэн зөв эсэх нь эргэлзээтэй байгаа тул иргэншил тогтоох ярилцлагад орох хүсэлт гаргах.

- Иргэншил тогтоосон тохиолдолд зорчих бичиг баримт / яаралтай зорчих бичиг баримт олгох хүсэлт гаргах.

G. АЖИГЛАЛТ

.....
.....……
.....
.....……
……
……

.....
(Гарын үсэг) (тамга/тэмдэг)

..... ……..… ..... ……..… ..... ……..… ..... ….	....
(Хүсэлт гаргагч улсын эрх бүхий байгууллагын төлөөллийн гарын үсэг)	(Газар, огноо)